

**“АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН АЛБАН ХААГЧИЙН АЛБАН ТУШААЛЫН
ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ” МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН АНХНЫ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ЯВУУЛСАН
ТАЛААРХ ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2021 оны 11 дүгээр
сарын 10-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2022 оны төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг нэгдсэн хуралдаанаар хийх үед төсвийн тооцоололтой холбоотойгоор шаардлагатай бол холбогдох хууль, тогтоолын төслийг боловсруулах санал дэмжигдсэн, мөн Авлигатай тэмцэх газраас Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоолго саналаа 2021 оны 10 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд албан бичгээр ирүүлсэн тул Авлигын эсрэг хуулийн 29 дүгээр зүйлийн 29.6 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40, 93 дугаар зүйлд тус тус заасны дагуу Төсвийн байнгын хорооноос “Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан 2021 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцэж дараах санал, дүгнэлтийг Та бүхэнд танилцуулж байна.

Авлигатай тэмцэх газрын албан тушаалын сарын цалингийн хэмжээг адил төстэй чиг үүрэг гүйцэтгэж байгаа төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишигтэй дүйцүүлэн “Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гаралгүй бөгөөд тогтоолын төслийг анхны хэлэлцүүлгээр нь батлуулах саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 75.0 хувийн саналаар дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн, тогтоолын төслийг баталж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**

Ч.ХҮРЭЛБААТАР

